

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн
19 дугаар тогтоолын Нэгдүгээр хавсралт



УУЛ-УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮН АРИЛЖААЛАХ БРОКЕРЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь “Монголын хөрөнгийн бирж” ХК (цаашид “Бирж” гэх)-ээс Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан брокерыг биржид гишүүнээр элсүүлэх, гишүүний арилжаанд оролцох эрхийг түр түдгэлзүүлэх, гишүүнчлэлээс хасах, арилжаанд оролцох эрхийг сэргээх болон гишүүнд тавих хяналт, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Гишүүн брокер (цаашид “Гишүүн” гэх) нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид Хороо гэх), Биржээс баталсан журам, дүрэм, заавар болон холбогдох бусад хууль тогтоомж, шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдөнө.
- 1.3 Бирж нь гишүүнээр элсэхээр өргөдөл гаргасан этгээдийн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх, гишүүнд арилжаанд оролцохтой холбогдох үйлчилгээг үзүүлэх, хяналт тавих, хариуцлага тооцох үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ нээлттэй, үл ялгаварлах зарчмыг баримтална.
- 1.4 Бирж болон гишүүний харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг энэхүү журмын Хавсралт 1-д тусгасан “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн гэрээ”-гээр зохицуулна.

ХОЁР. ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1 Биржид гишүүнээр элсэх өргөдөл гаргагч брокер нь Хорооны “Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үйл ажиллагаанд хяналт тавих журам”-д зааснаас гадна дараах шаардлагуудыг хангасан байна:
 - 2.1.1 Хорооноос Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байх;
 - 2.1.2 Энэхүү журмын 3 дугаар хавсралтад заасан үйлчилгээний хөлсийг төлсөн байх;
 - 2.1.3 Биржийн болон холбогдох журамд заасан шаардлагын дагуу барьцаа хөрөнгө байршуулах санхүүгийн чадвартай байх;
 - 2.1.4 Уул уурхайн бүтээгдэхүүний зохицуулалттай зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомжтой бүрэн танилцсан, тэдгээр хууль тогтоомжийг мөрдөн ажиллах, харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа шударгаар, мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэхийг баталсан

баталгааг компанийн эрх бүхий албан тушаалтан болон арилжааны үйл ажиллагаанд оролцох ажилтан тус бүр Хавсралт 2-ийн дагуу гаргасан байх;

2.1.5 Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх;

2.1.6 Хууль тогтоомж, дүрэм журамд заасан бусад шаардлага.

ГУРАВ. ГИШҮҮНЭЭР ЭЛСҮҮЛЭХ, ТАТГАЛЗАХ ТУХАЙ ШИЙДВЭР ГАРГАХ

3.1 Гишүүнээр элсэх өргөдөл гаргах

- 3.1.1 Гишүүнээр элсэхээр өргөдөл гаргагч нь холбогдох хууль, журамд заасан шаардлагуудыг бүрэн хангасан бичиг баримтын хамт энэхүү журмын Хавсралт 2-т заасан өргөдлийн маягтыг бөглөж ирүүлнэ.
- 3.1.2 Биржийн холбогдох нэгж нь журмын 3.1.1-т заасан баримт бичгийг хүлээн авсан өдрөөс эхлэн ажлын 5 хоногт багтаан хянаж, холбогдох шаардлага хангасан эсэх тухай дүгнэлт гарган Хороонд хүргүүлнэ.
- 3.1.3 Брокерт Хорооноос тусгай зөвшөөрөл олгосон тохиолдолд тусгай зөвшөөрлийг Бирж хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор Биржийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-д танилцуулж гишүүнээр элсүүлэх эсэх тухай шийдвэр гаргана.
- 3.1.4 Бирж нь шаардлагатай тохиолдолд нэмэлт тодруулга ирүүлэхийг шаардаж, энэхүү журмын 3.1.2-т заасан хугацааг нэг удаа ажлын 5 хүртэл өдрөөр сунгаж болно.
- 3.1.5 Өргөдөл гаргагч нь өргөдлийн албан баримт бичгийг зохих стандартын дагуу боловсруулан, эмхлэн товъёоглож, Гүйцэтгэх захирлын гарын үсэг, тэмдгээр баталгаажуулсан байна.
- 3.1.6 Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гишүүнээр бүртгүүлэхдээ холбогдох бичиг баримтуудыг Монгол хэл дээр үйлдэн баталгаажуулж ирүүлнэ.
- 3.1.7 Өргөдлийг хүлээн авч хянах явцад ирүүлсэн бичиг баримтад нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд өргөдөл гаргагч нь энэ тухайгаа ажлын 3 өдрийн дотор Биржид мэдэгдэнэ.

3.2 Гишүүнээр элсүүлэх, элсүүлэхээс татгалзах тухай шийдвэр гаргах

- 3.2.1 Биржийн гишүүнчлэл хариуцсан нэгж нь элсэх хүсэлт гаргагчийн баримт бичгийн бүрдэл, биржийн гишүүн оролцогчид тавих шаардлага хангасан эсэхийг хянаж, гишүүнээр элсүүлэх эсэх талаар саналаа ТУЗ-д гаргаж, ТУЗ-өөр шийдвэрлүүлнэ.
- 3.2.2 Гишүүнээр элсүүлэх тухай ТУЗ-ийн шийдвэрийн дагуу өргөдөл гаргагч нь “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн гэрээ”-г Биржтэй байгуулснаар Биржийн гишүүнээр элссэнд тооцно.
- 3.2.3 “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн гэрээ” байгуулахаас татгалзсан, энэхүү журмын 3.3-д заасан татгалзах үндэслэл бүхий тохиолдолд энэ талаарх холбогдох нэгжийн дүгнэлтийг үндэслэн ТУЗ-өөс гишүүнээр элсүүлэхээс татгалзах эсэх шийдвэр гаргах бөгөөд, Биржийн гишүүнчлэл хариуцсан нэгжээс хүсэлт гаргагчид албан бичиг хүргүүлнэ.

3.3 Биржийн гишүүнээр элсүүлэхээс татгалзах үндэслэл:

- 3.3.1 Бичиг баримт нь зөрчилтэй, мэдээллийн зөрүүтэй, Биржээс өргөдөлтэй холбогдуулан шаардсан мэдээллийг бүрэн ирүүлээгүй;
- 3.3.2 Хорооноос баталсан “Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үйл ажиллагаанд хяналт тавих журам”, эсхүл энэхүү журамд заасан шаардлагыг хангаагүй;
- 3.3.3 Гишүүнээр элсүүлэхээс татгалзсан шийдвэртэй этгээд нь 6 сарын дотор Биржид дахин элсэх хүсэлт гаргасан;
- 3.3.4 Өргөдөл гаргагчийг гишүүнээр элсүүлэх нь уул уурхайн бүтээгдэхүүний зохицуулалттай зах зээлд сонирхлын зөрчил үүсгэнэ гэж эрх бүхий байгууллагаас үзсэн;
- 3.3.5 Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаас хойш 1 сарын дотор тусгай зөвшөөрлөө Биржид ирүүлээгүй.
- 3.3.6 Хуурамч бичиг баримт бүрдүүлсэн гэх үндэслэлээр гишүүнээр элсүүлэхээс татгалзсан компани нь 3-н жилийн дотор дахин гишүүнээр элсэх хүсэлт гаргасан.

3.4 Гишүүнд үзүүлэх үйлчилгээний хөлс

- 3.4.1 Гишүүн үйлчилгээний хөлсийг энэхүү журмын Хавсралт 3-т заасны дагуу Биржид төлнө.
- 3.4.2 Гишүүний арилжаанд оролцох эрхийг түр түдгэлзүүлсэн нь гишүүнчлэлийн хөлс төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 3.4.3 Гишүүнээс хасагдсан тохиолдолд гишүүнчлэлийн элсэлтийн болон жилийн хөлсийг буцаан олгохгүй.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Бирж дараах эрх эдэлнэ:

- 4.1.1 Гишүүний үйл ажиллагаанд хяналт тавих, журам, заавар, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах зорилгоор шалгалт хийж, энэхүү журмын 5.7-д заасны дагуу арга хэмжээ авах;
- 4.1.2 Энэхүү журам болон “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн гэрээ”-нд заасан үйлчилгээний хөлсийг тогтоосон хугацаанд төлөхийг шаардах;
- 4.1.3 Гишүүний гаргасан зөрчил нь гэмт хэргийн шинжтэй, эсхүл зөрчлийн шинжтэй тохиолдолд эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлэх;
- 4.1.4 Үйлчилгээний хөлсийг зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан өөрчлөх;
- 4.1.5 Хууль тогтоомж болон Хороо, Биржийн журмаар тогтоосон бусад эрх.

4.2 Бирж дараах үүрэг хүлээнэ:

- 4.2.1 Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хороо болон Биржээс баталсан журам, зааврын дагуу өдөр тутмын арилжааг зохион байгуулах, арилжааны програмын хэвийн ажиллагааг хангаж, мэдээллийн нууцлалыг хадгалах;
- 4.2.2 Гишүүний хүсэлтээр арилжаатай холбоотой мэдээ, баримт, материалыг цаг тухайд нь холбогдох журмын дагуу гаргаж өгөх;
- 4.2.3 Гишүүдийн хууль тогтоомжоор болон “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн гэрээ”-ээр хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэх;
- 4.2.4 Гишүүнээс хассан, арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлсэн, сэргээсэн болон эрх бүхий байгууллагаас гишүүний үйл ажиллагаатай холбоотой авсан арга хэмжээ, гэрээний үүргийн биелэлтийн талаарх мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх;
- 4.2.5 Хууль тогтоомж, Хорооноос баталсан журам, зааврын дагуу олон нийтэд мэдээлвэл зохих бусад мэдээллийг зохих журмын дагуу мэдээлэх ;
- 4.2.6 Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн шийдвэр, шаардлагыг биелүүлэх.

4.3 Гишүүн нь дараах эрх эдэлнэ:

- 4.3.1 Биржээс зохион байгуулж буй уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаанд оролцох;
- 4.3.2 Бүтээгдэхүүний үнэ, ханшийн болон зах зээлийн холбогдолтой нийтэд тараагдах мэдээ, мэдээллийг холбогдох зардлыг төлж, гаргуулан авах;
- 4.3.3 Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээл, Бирж, Гишүүдийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр санал гаргах, хамтран ажиллах;
- 4.3.4 Биржийн жилийн, хагас жилийн санхүүгийн тайлантай танилцах;
- 4.3.5 Биржид санал хүсэлт гаргах, тогтоосон хугацаанд хариу авах, асуудлыг хамтран шийдвэрлэх, харилцан зөвшилцөх;
- 4.3.6 Биржийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд Хороонд гомдол гаргаж шийдвэрлүүлэх.
- 4.3.7 Хууль тогтоомж болон Хороо, Биржийн журмаар тогтоосон бусад эрх.

4.4 Гишүүн нь дараах үүрэг хүлээнэ:

- 4.4.1 Биржийн гишүүн байх хугацаандаа энэхүү журмын 2 дугаар зүйл болон “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн гэрээ”-нд заасан шаардлагуудыг биелүүлж ажиллах;
- 4.4.2 Энэхүү журамд заасан үйлчилгээний хөлс болон холбогдох бусад төлбөрийг цаг тухайд нь тогтмол төлөх;
- 4.4.3 Өөрийн үйл ажиллагаа болон Биржид буй гишүүний мэдээлэлтэй холбоотой өөрчлөлтүүд, мэдээллийг ажлын 5 хоногт Биржид албан бичгээр ирүүлэх;
- 4.4.4 Гишүүн нь мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах;
- 4.4.5 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа оны 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор, хагас жилийн санхүүгийн тайланг өмнөх жилийн аудитын дүгнэлтийн

- хамт 7-р сарын эхний ажлын долоо хоногт багтаан Биржид тус тус ирүүлэх;
- 4.4.6 Шаардлагатай мэдээ, мэдээлэл, нотлох баримт бичгийг Биржийн шаардсанаар гаргаж өгөх;
- 4.4.7 Гишүүн нь өөрийн компанийн албан ёсны цахим хуудсыг тогтмол ажиллуулж, дараах мэдээ мэдээллийг өөрийн болон Биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлэх:
- 4.4.7.1 Сар бүрийн уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны тайлан, мэдээ;
- 4.4.7.2 Жилийн болон хагас жилийн санхүүгийн тайлан;
- 4.4.7.3 Компанийн эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл;
- 4.4.7.4 Компанийн хаяг, байршил түүнд орсон өөрчлөлт;
- 4.4.7.5 Холбогдох хууль болон Хороо, Биржийн дүрэм, журмаар хүлээсэн үүргийн хэрэгжилт.
- 4.4.8 Гишүүний тусгай зөвшөөрөл хүчингүй болсноор Гишүүний эрх цуцлагдсантай холбоотой холбогдох баримтуудыг тогтоолд заасан этгээдэд хүлээлгэн өгөх;
- 4.4.9 Биржийн зах зээлийн оролцогчтой хамтран ажиллах, биржийн арилжаанд оролцоходоо гэрээний үндсэн дээр оролцох;
- 4.4.10 Гишүүн нь харилцагчийн хэлцлийн жагсаалтыг захиалгатай тулгаж, цаг хугацааны дарааллаар жагсаан, харилцагчаас олгосон эрхийн хүрээнд ажиллах;
- 4.4.11 Гишүүн нь арилжаанд оролцож харилцагчийн захиалгыг оруулахдаа харилцагчийн зөвшөөрлийг цахим эсхүл бусад хэлбэрээр баримтжуулах;
- 4.4.12 Харилцагчийн мөнгөн хөрөнгийг тусдаа дансанд байршуулж, харилцагч тус бүрийн нэрээр, арилжих гэрээний төрөл бүрээр бүртгэл хөтлөх;
- 4.4.13 Гишүүн нь харилцагчийн дэнчинг байршуулсан, буцаан авах хүсэлтийг харилцагч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгчийн гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажуулж, тухайн шилжүүлэг хийгдсэн санхүүгийн баримтыг хавсарган Биржид цахимаар ирүүлэх;
- 4.4.14 Гишүүн нь үйлчлүүлэгчдэд цахим үйлчилгээ үзүүлэх тохиолдолд цахим арилжааны талаар өөрийн журамд тусгаж, арилжааны эрсдэлийн талаар үйлчлүүлэгчдэд тусгайлан анхааруулж ажиллах;
- 4.4.15 Гишүүн нь уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлд оролцогчдод үндэслэлгүй, албан бус мэдээ, мэдээлэл тараахгүй байх.

ТАВ.ХАРИУЦЛАГА

- 5.1. Биржийн Гишүүн хариуцсан нэгжээс энэхүү журмын хэрэгжилтэд тавих хяналт шалгалт нь дараах хэлбэртэй байна:
- 5.1.1. Зайны хяналт;
- 5.1.2. Газар дээрх хяналт;

- 5.2. Газар дээрх хяналтыг батлагдсан удирдамжийн дагуу хэрэгжүүлнэ. Удирдамжид дараах мэдээллийг тодорхой тусгасан байна:
 - 5.2.1. Шалгалтын агуулга, зорилго;
 - 5.2.2. Шалгалтын хамрах хугацаа;
 - 5.2.3. Шалгалтын бүрэлдэхүүн;
 - 5.2.4. Шалгалтын хамрах хүрээ, чиг үүрэг;
 - 5.2.5. Шалгалтын ажилд шаардлагатай баримт бичгийн бүрдэл;
 - 5.2.6. Шалгалтын ажлын үр дүнг үнэлэх аргачлал.
- 5.3. Гишүүнийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт, шалгалтын тайлангаас Байгууллагын нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар хамгаалагдсан мэдээлэл нь нууц байна.
- 5.4. Гишүүн нь хяналт, шалгалтын ажлын удирдамжтай бүрэн танилцах эрхтэй бөгөөд шалгалтын бүрэлдэхүүнийг ажлын байр, ажиллах нөхцөлөөр хангана.
- 5.5. Зөрчил илэрсэн тохиолдолд тухайн зөрчлөөс хамаарч шалгалтын бүрэлдэхүүн зөрчил арилгах хугацаат үүрэг даалгаврыг гишүүнд хүргүүлнэ.
- 5.6. Биржийн гишүүн хяналт, шалгалтын тайланд заасан хугацаанд зөрчлийг арилгаж, зөрчил арилгасан тухайгаа Биржид албан бичгээр мэдэгдэнэ.
- 5.7. Бирж нь Гишүүний үйл ажиллагаанд илэрсэн зөрчлийг харгалзан дор дурдсан арга хэмжээг авна:
 - 5.7.1. Сануулах:
 - 5.7.1.1. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хороо, Биржээс гаргасан дүрэм, журам болон гэрээгээр хүлээсэн үүргийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй;
 - 5.7.1.2. Энэхүү журмын 4.4 дэх үүргээ биелүүлээгүй.
 - 5.7.2. Арилжаанд оролцох эрхийг 3-н сар хүртэл хугацаагаар түр түдгэлзүүлэх:
 - 5.7.2.1. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон Хорооны Улсын байцаагчийн албан шаардлагаар;
 - 5.7.2.2. Энэхүү журмын 3.4.1 дэх заалт болон “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн гэрээ”-нд заасан аливаа хөлсийг хугацаанд нь төлж барагдуулалгүй хуанлийн 30-аас дээш хоног хугацаа хэтэрсэн;
 - 5.7.2.3. Энэхүү журмын 5.7.1 дэх заалтыг 2 болон түүнээс дээш удаа зөрчсөн;
 - 5.7.2.4. Сануулах арга хэмжээний хүрээнд Биржээс өгсөн үүрэг, даалгаврыг заасан хугацаанд биелүүлээгүй;
 - 5.7.2.5. Биржийн журам, зааврыг зөрчиж харилцагчийн эрх ашгийг хөндөх, зах зээлийн шударга байдлыг алдагдуулах нөхцөлд хүргэсэн нь тогтоогдсон;
 - 5.7.2.6. Гишүүний ажилтан нь уул уурхайн бүтээгдэхүүний зохицуулалттай зах зээлд мөрдөгдөж буй ёс зүйн хэм хэмжээг удаа дараа зөрчсөн;

- 5.7.2.7. Олон нийтийг төөрөгдүүлсэн зар сурталчилгаа, хуурамч мэдээлэл тараасан;
- 5.7.2.8. Арилжааны явцад зохиомлоор үнэд нөлөөлөх, үгсэн хуйвалдах оролдлого, зах зээлийг урвуулан ашиглах үйлдэл гаргасан,
- 5.7.2.9. Сүүлийн нэг жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй, эсхүл нэг жилийн хугацаанд уул уурхайн бүтээгдэхүүний арилжаанд оролцоогүй.

5.7.3. Гишүүнээс хасах:

- 5.7.3.1. Гишүүнчлэлээс гарах хүсэлт гаргасан;
- 5.7.3.2. Гишүүний арилжаанд оролцох эрхийг түр түдгэлзүүлснээс хойш 3 сарын хугацаанд эрхээ сэргээлгэх талаар арга хэмжээ аваагүй;
- 5.7.3.3. Хорооноос уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон;
- 5.7.3.4. Гишүүний төлбөрийн чадвар алдагдсан, эсхүл төлбөрийн чадваргүй болсон, эсхүл түүнийг татан буулгах ажиллагаа эхэлсэн, дампуурсан, дампуурлын хэрэг үүссэн зэрэг нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;
- 5.7.3.5. Биржийн “Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны хяналт шалгалтын журам”-ын дагуу Биржийн хяналт, шалгалт хариуцсан нэгжээс гишүүний эрхийг цуцлах тухай санал гаргасан;
- 5.7.3.6. Энэ журмын 3.4.1 дэх заалт болон “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн гэрээ”-нд заасан аливаа хөлсийг тогтоосон хугацаанд төлж барагдуулалгүй 6-н сараас дээш хугацаа өнгөрсөн;
- 5.7.3.7. Биржийн уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, гишүүнчлэл, хяналтын үйл ажиллагаатай холбоотой журам болон холбогдох бусад хууль тогтоомжийг удаа дараа, эсхүл ноцтой зөрчсөн;
- 5.7.3.8. Биржийн болон дотоодын уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн нэр хүндэд харшлах үйл ажиллагаа, үйлдэл хийсэн нь тогтоогдсон;
- 5.7.3.9. Гишүүнээр элсэхдээ хуурамч баримт бүрдүүлсэн нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон;
- 5.7.3.10. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, дүрэм, журам, гэрээ болон холбогдох эрх зүйн актанд заасан бусад үндэслэл.

5.8. Дараах тохиолдолд гишүүний арилжаанд оролцох эрхийг сэргээнэ:

- 5.8.1. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон Хорооны Улсын байцаагчийн албан шаардлагаар;

- 5.8.2. Гишүүн гаргасан зөрчлөө арилгасан тухайгаа мэдэгдэж, Биржээс уг зөрчлийг арилсан гэж тогтоосон;
- 5.8.3. Хорооноос гишүүний тусгай зөвшөөрлийг сэргээсэн;
- 5.8.4. Хууль тогтоомж, дүрэм, журамд заасан бусад үндэслэл.
- 5.9. Энэ журмын 5.7.1, 5.7.2-д заасан хариуцлагын арга хэмжээг хариуцсан нэгжийн саналыг үндэслэн Гүйцэтгэх захирал шийдвэрлэнэ.
- 5.10. Энэ журмын 5.7.3-д заасан хариуцлагын арга хэмжээг хариуцсан нэгжийн саналыг үндэслэн ТУЗ шийдвэрлэнэ.
- 5.11. Бирж нь гишүүнээс хассан тохиолдолд өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд болон гишүүнд мэдэгдэнэ.

ЗУРГАА. БУСАД

- 6.1. Энэхүү журмыг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах тохиолдолд ТУЗ баталж, Хороо батламжилснаар хүчин төгөлдөр болно.
- 6.2. Гишүүн нь Биржээс гаргасан шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 30 хоногийн дотор тус шийдвэртэй холбоотой гомдлыг Хороонд гаргах эрхтэй.

-----oOo-----

Батлав. “Монголын хөрөнгийн бирж”
ХХК-
ХК-ийн Гүйцэтгэх захирал

Батлав. “.....”
ийн Гүйцэтгэх захирал

.....

.....

УУЛ-УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮН
АРИЛЖААЛАХ БРОКЕРЫН
ГИШҮҮНЧЛЭЛИЙН ГЭРЭЭ

201... оны ... сарын... -ны өдөр
хот

№...

Улаанбаатар

Нэг талаас “Монголын хөрөнгийн бирж” ХК (цаашид “Бирж” гэх), түүнийг төлөөлөн
....., нөгөө талаас “.....”
ХХК (цаашид “Гишүүн”, хамтад нь “талууд” гэх) нар дараах нөхцлийг харилцан
тохиролцож энэхүү гэрээг нэг жилийн хугацаатай байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээгээр Бирж нь брокерын компанийг гишүүнээр элсүүлж, уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлд арилжаа явуулах нөхцөл, дэд бүтцээр хангах, Гишүүн нь харилцан тохиролцсон гишүүнчлэлийн хөлсийг төлөхтэй холбогдон үүсэх харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.
- 1.2 Талууд үйл ажиллагаандаа Иргэний хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид “Хороо” гэх) болон Биржээс баталсан журам, заавар болон энэхүү гэрээг дагаж мөрдөнө.
- 1.3 Холбогдох харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд, эсхүл талуудын хүсэлтээр харилцан тохиролцож гэрээнд өөрчлөлт оруулж болно.
- 1.4 Талууд хамтран ажиллахдаа бизнесийн болон ажил хэргийн нэр хүндийг гуравдагч этгээдийн өмнө харилцан хамгаалж, хууль ёсны эрх ашгийг хүндэтгэнэ.
- 1.5 Гишүүн нь гишүүнээр элсэхэд тавигдах шаардлага, үйл ажиллагаа явуулахад тавигдах нөхцөл шаардлагыг хангаж байгаа гэх баталгаа гаргаж байгаа бөгөөд уг баталгааг зөрчсөнөөс үүсэх хариуцлагыг бие даан хариуцна.

ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1 Бирж дараах эрх эдэлнэ:

- 2.1.1 “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журам” болон энэхүү гэрээнд заасан үйлчилгээний хөлс, холбогдох бусад төлбөрийг цаг тухайд нь төлүүлэх, тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журам”-д заасны дагуу хариуцлага тооцох;
- 2.1.2 Гишүүний хууль, дүрэм, журам, гэрээгээр хүлээсэн үүрэг болон Биржээс гаргасан шийдвэрийг биелүүлэхийг шаардах;
- 2.1.3 Гишүүний санхүүгийн тайлан мэдээ, удирдлага, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүний талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэх;
- 2.1.4 Гишүүний үйл ажиллагаанд хяналт тавьж, өргөдөл, гомдлын дагуу болон журам, заавар, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах зорилгоор шалгалт хийж, Биржийн холбогдох журам, гэрээнд заасны дагуу хариуцлага тооцох;
- 2.1.5 Гишүүний гаргасан зөрчил нь гэмт хэргийн, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан шинжтэй бол эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлэх.

2.2 Биржийн хүлээх үүрэг:

- 2.2.1 Өдөр тутмын уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хороо болон Биржийн холбогдох журмын дагуу зохион байгуулах, арилжааны програмын хэвийн ажиллагааг хангах;
- 2.2.2 Гишүүний гаргасан хүсэлтийн дагуу түүний техник тоног төхөөрөмж, програм хангамжийг Биржийн сүлжээнд анх холбоход шаардлагатай мэргэжлийн туслалцааг үнэ төлбөргүйгээр үзүүлэх, арилжааны системийг ашиглах заавар, зөвлөгөө өгөх;
- 2.2.3 Харилцагч болон гишүүнээс ирүүлсэн санал, хүсэлтэд холбогдох алба, нэгж нь утсаар болон бусад арга, хэрэгслээр хариу өгөх;
- 2.2.4 Гишүүнийг уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаанд оролцох, мэдээлэл авах ижил нөхцлөөр хангах.

2.3 Гишүүн нь дараах эрх эдэлнэ:

- 2.3.1 Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа, үнэ ханшийн болон зах зээлийн холбогдолтой нийтэд тараагдах мэдээ, мэдээллийг холбогдох зардлыг төлж гаргуулан авах;
- 2.3.2 Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээл, Бирж, Гишүүний үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр санал гаргах, Биржтэй хамтран ажиллах;

2.3.3 Биржийн жилийн санхүүгийн тайлантай танилцах;

2.3.4 Биржид санал гаргах, тогтоосон хугацаанд хариу авах, шийдвэрлэх асуудлаар харилцан зөвшилцөх;

2.3.5 Биржийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд Хороонд гомдол гаргах.

2.4 Гишүүн нь дараах үүрэг хүлээнэ:

2.4.1 Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаанд Биржийн “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журам”-д заасан шаардлага хангасан тоног төхөөрөмж, програм хангамж ашиглаж, түүний аюулгүй, тасралтгүй ажиллагааг өөрийн зардлаар хариуцна.

2.4.2 Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаанд оролцогч нь арилжаанд оролцох эрх авсан байх;

2.4.3 “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журам”-д заасны дагуу дараах үйлчилгээний хөлсийг тогтоосон хугацаанд төлнө:

2.4.3.1 Гишүүнчлэлийн хөлсийг улирал бүрийн хуанлийн эхний 10 хоногийн дотор;

2.4.3.2 Арилжааны системд нэвтрэх эрхийн төлбөрийг улирал бүрийн хуанлийн эхний 10 хоногийн дотор.

2.4.4 Гишүүний ажлын байрны байршил, хаяг тодорхой, ойлгомжтой байх ба, хаягийн өөрчлөлтийг ажлын 3 хоногийн дотор биржид мэдээлэх;

2.4.5 Биржид дараах мэдээллийг тогтоосон хугацаанд ирүүлэх:

2.4.5.1 Жилийн эцсийн болон улирал бүрийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журам”-д заасан хугацаанд ирүүлэх;

2.4.5.2 Компанийн дүрэм, журамд орсон өөрчлөлтийг ажлын 10 хоногийн дотор албан бичгээр мэдэгдэх;

2.4.5.3 Компанийн гүйцэтгэх захирал болон арилжаанд оролцох эрх авсан этгээдийн талаарх мэдээлэл, түүнд орсон өөрчлөлтийг ажлын 10 хоногийн дотор албан бичгээр мэдэгдэх;

2.4.5.4 Биржээс шаардсан бусад мэдээлэл

2.4.6 Гишүүн нь арилжаанд оролцож харилцагчийн захиалгыг оруулахдаа харилцагчийн зөвшөөрлийг цахим эсхүл бусад хэлбэрээр баримтжуулах, Биржээс шаардсан тохиолдолд уг баримтыг ирүүлэх;

2.4.7 Гишүүн нь өөрийн цахим хуудастай байж харилцагчдыг шаардлагатай мэдээ мэдээллээр тогтмол хангаж ажиллах.

ГУРАВ. ХАРИЛЦАА ХОЛБОО

3.1 Бирж нь мэдээллийг Биржийн цахим хуудас, эсхүл цахим шуудангаар болон албан бичгээр Гишүүнд хүргүүлнэ.

3.2 Гишүүн нь аливаа мэдээлэл, санал, хүсэлт, гомдлыг албан бичгээр эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулж цахимаар Биржид хүргүүлнэ.

3.3 Энэхүү гэрээний 3.1-д заасны дагуу Биржээс мэдээллийг өөрийн цахим хуудсанд байршуулснаар Гишүүнийг танилцсанд тооцох ба Гишүүн нь хүсэлт гаргавал албан бичгээр авч болно.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

4.1 Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлээгүйгээс учирсан хохирлыг буруутай тал хариуцан барагдуулна.

4.2 Гишүүн нь “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журам” болон гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд Биржийн холбогдох журамд заасан хариуцлагыг ногдуулна.

ТАВ. БУСАД ЗҮЙЛ

5.1 Цахилгаан эрчим хүч, сүлжээний дэд бүтэц (үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас хамаарах) болон Биржийн үйл ажиллагаанаас үл хамаарах бусад гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцлийн улмаас үүссэн аливаа хохирлыг Бирж хариуцахгүй.

5.2 Энэхүү гэрээний хугацаа дуусахаас өмнө Гишүүн нь сунгуулах хүсэлт гаргаж, Бирж татгалзаагүй тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

5.3 Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэх бөгөөд 30 хоногийн дотор тодорхой шийдвэрт хүрч чадаагүй тохиолдолд шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийг
төлөөлөн:

“.....” ХХК-ийг
төлөөлөн:

.....

/...../

.....

/...../

ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ:

20..... оны сарын өдрийг хүртэл сунгав.

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийг
төлөөлөн:

.....

.....

/...../
/...../

“.....” ХХК-ийг
төлөөлөн:

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХЭЭР
ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ КОМПАНИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ

НЭГ. КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

1	<i>Компанийн ерөнхий мэдээлэл</i>		
1.1	Компанийн нэр		
1.2	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар		
1.3	Регистрын дугаар		
1.4	Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн		
1.5	СЗХ-ны тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрөл авсан огноо	Шийдвэрийн дугаар
	Спот		
	Форвард		
	Фьючерс		
	Опцион		
	Бусад		
2	<i>Үйлчилгээний нөхцөл</i>		
2.1	Данс нээх хураамж		
2.2	Арилжааны шимтгэл	Уул уурхайн бүтээгдэхүүн	
2.3	Харилцагч банк	<i>Нэр</i>	<i>Дансны дугаар</i>
2.4	Төлбөр тооцоо гүйцэтгэгч банкны нэр		
3	<i>Хаяг, байршил</i>		
3.1	Ажлын байрны талаарх мэдээлэл	<input type="checkbox"/> Өөрийн	<input type="checkbox"/> Түрээс
3.2	Байршил	Төв: Салбар:.....	
3.3	Цахим хуудас		
3.4	И-мэйл хаяг		
3.5	Ажлын утас, факс		
4	<i>Үүсгэн байгуулагч</i>		

№	Овог, нэр	Оруулсан хөрөнгийн		Ажил эрхлэлтийн байдал	
		Үнийн дүн	Хувь		
5	<i>Төлөөлөн удирдах зөвлөл</i>				
№	Овог, нэр	Албан тушаал		Ажил эрхлэлт	
1					
2					
3					
4					
5					
6					
6	<i>Санхүүгийн үзүүлэлт (..... оны сарын –ны байдлаар)</i>				
№	Үзүүлэлт	Актив		Пассив	
1	Нийт хөрөнгө				
	Эргэлтийн хөрөнгө				
	Эргэлтийн бус хөрөнгө				
2	Өр төлбөр, Эзэмшигчийн өмчийн дүн				
	Өр төлбөр				
	Эзэмшигчийн өмч				
3	Тэнцэл				
4	Аудит хийсэн компани	Нэр:		Хаяг:	
7	<i>Ажиллагсдын мэдээлэл (салбарыг оролцуулна)</i>				
№	Ажилтнуудын овог, нэр	Албан тушаал	Ажилд орсон огноо	УУБЗЗ-д мэргэжлийн ажил, үйлчилгээ эрхлэх үнэмлэхийн дугаар	
1					
2					
3					
4					
5					
6					
8	<i>Бусад мэдээлэл</i>			<i>Тийм</i>	<i>Үгүй</i>
1	Өргөдөл гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч эсхүл толгой компани нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг				

	ноцтойгоор зөрчиж байсан, сүүлийн 5 жилийн хугацаанд зөрчлийн улмаас тусгай зөвшөөрөл нь хүчингүй болж, гишүүний эрх нь цуцлагдсан үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдэд эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан эсэх		
2	Өргөдөл гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, толгой компани дампуурсан, төлбөрийн чадваргүйд тооцогдож байсан эсэх		
3	Өргөдөл гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч эсхүл толгой компани нь эдийн засгийн гэмт хэрэгт холбогдон буруутай нь тогтоогдсон эсхүл сэжиглэгдэн шалгагдаж байгаа эсэх		
<i>*“Тийм” хариултын тайлбарыг хавсаргана уу.</i>			
9	<i>Бүрдүүлэх материалын жагсаалт</i>		
	<p>Дараах баримт бичгийг энэхүү өргөдлийн маягтын хамт ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Биржид гишүүнээр элсэх тухай хүсэлт (албан бичгээр); 2. Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх байгууллага байгуулах тухай үүсгэн байгуулагчийн шийдвэр; 3. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; 4. Компанийн дүрмийн баталгаажсан хуулбар; 5. Бизнес төлөвлөгөө (1-3 жил); 6. Санхүүгийн аудитлагдсан тайлан баланс, шинээр байгуулагдсан компани бол эхлэлтийн баланс; 7. Харилцах дансны баталгаажсан хуулга (сүүлийн 3 сараас доошгүй хугацааны дансны хуулга); 8. Харилцагч банкны дансны үлдэгдэлтэй тодорхойлолт, (СЗХ-ноос тусгай зөвшөөрөл авсны дараа Биржид гишүүнээр элсэх үед); 9. Үүсгэн байгуулагч, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, албан тушаалтнуудын татварын байгууллагад өр төлбөртэй эсэх талаарх тодорхойлолт; 10. Үүсгэн байгуулагч, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, албан тушаалтнуудын өр төлбөртэй эсэх талаарх ШШГЕГ-ын тодорхойлолт; 11. Албан тушаалтны мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэхийн хуулбар, их, дээд сургуулийн дипломын хуулбар, “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журам”-ын хавсралтаар баталсан дэлгэрэнгүй анкет; 12. Тоног төхөөрөмж, эд хөрөнгийн жагсаалт, журамд заасан шаардлага хангасан эсэхийг тодорхойлох баримт; 13. Түрээсийн гэрээ эсхүл үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ; 14. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухайн хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны журмын дагуу дотооддоо мөрдөхөөр гаргасан журам, зааврууд; 		

15. Үйлчилгээний хөлс төлсөн баримт;
16. Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар, СЗХ-ны тогтоолын хуулбар.

Албан ёсны бичиг баримтын хуулбар байх шаардлагатай.

Энэхүү жагсаалтын 8, 16 дугаарт заасан баримт бичгийг СЗХ-ноос зохих тусгай зөвшөөрөл авсны дараа ирүүлнэ.

10

Батламж

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүнээр элсэхээр өргөдөл гаргагч “.....” компани нь “Монголын хөрөнгийн бирж” ХК-д ирүүлсэн материалын үнэн зөвийг хариуцах бөгөөд хуурамч, худал мэдээлэл ирүүлсэн нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ. Цаашид Монгол Улсын хууль тогтоомж, Үнэт цаасны болон Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлд мөрдөгдөж буй Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн холбогдох журам, заавар, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллахыг БАТАЛЖ байна.

/Тамга/

Захирал / Гарын үсэг /

20... оны ... сарын ... -ний өдөр

**ХОЁР: КОМПАНИЙН АРИЛЖААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ
ХОЛБОГДОХ АЖИЛТНЫ ГАРГАХ ТОДОРХОЙЛОЛТ**

1 Ерөнхий мэдээлэл						
1.1	Овог			Цээж зураг 3x4 см		
1.2	Нэр					
1.3	Хүйс (сонгох)	Эрэгтэй:	Эмэгтэй:			
1.4	Төрсөн он, сар, өдөр					
1.5	Иргэний харьяалал					
1.6	Иргэний бүртгэлийн дугаар					
1.7	И-мэйл хаяг:					
1.8	Гэрийн хаяг					
1.9	Холбоо барих утас:	1.	2.			
2 Боловсрол						
2.1	Төгссөн сургуулийн нэр	Хаана	Элссэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил	Диплом, Гэрчилгээний дугаар
2.2	Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэх	Дугаар:		Авсан огноо:	Дуусах огноо:	
3 Ажлын туршлага (Одоо эрхэлж буй ажлыг оролцуулан бичнэ)						
3	Хаана, ямар албан байгууллагад	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажлаас гарсан огноо	Ажлаас гарсан шалтгаан	
4 Нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээлэл						
4	Ямар хамааралтай болох	Овог нэр	Иргэний бүртгэлийн дугаар	Төрсөн газар	Одоо эрхэлж буй ажил	

5	Батламж
---	----------------

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүнээр элсэхээр өргөдөл гаргагч “.....” компанийн (албан тушаал, хөрөнгө оруулагч) овогтой нь “Монголын хөрөнгийн бирж” ХК-д ирүүлсэн материалын үнэн зөвийг хариуцах бөгөөд хуурамч, худал мэдээлэл ирүүлсэн нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ. Цаашид Монгол Улсын хууль тогтоомж, Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлд мөрдөгдөж буй Санхүүгийн Зохицуулах Хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн холбогдох журам, заавар, гэрээтэй бүрэн танилцсан бөгөөд цаашид хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллахыг БАТАЛЖ байна.

Батламжилсан:

/Гарын үсэг/

БҮРТГЭЛИЙГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:
үсэг/

/Гарын

БҮРТГЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

/Компанийн захирал/

20 ... оны сарын өдөр

ГУРАВ: ГИШҮҮН КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Д/д	<i>Компанийн ерөнхий мэдээлэл</i>		
1	Компанийн нэр		
2	Байгуулагдсан огноо		
3	Иргэний бүртгэлийн дугаар		
4	Компанийн харьяалал		
5	Үйл ажиллагааны чиглэл		
6	Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн		
7	Гишүүн компани дахь эзэмшлийн мэдээлэл	Оруулсан хөрөнгийн үнийн дүн:	Оруулсан хөрөнгийн хувь:
8	Удирдлагын нэр		
9	Компанийн хаяг		
10	Вэб сайт		
11	И-мэйл хаяг		
12	Холбоо барих утас, факс		
13	Эцсийн өмчлөгч		

**ДӨРӨВ: КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ГАРГАХ БАТАЛГААНЫ
МАЯГТ**

1 Ерөнхий мэдээлэл						
1.1	Овог			Цээж зураг 3x4 см		
1.2	Нэр					
1.3	Хүйс (сонгох)	Эрэгтэй:	Эмэгтэй:			
1.4	Төрсөн он, сар, өдөр					
1.5	Иргэний харьяалал					
1.6	Иргэний бүртгэлийн дугаар					
1.7	И-мэйл хаяг:					
1.8	Гэрийн хаяг					
1.9	Холбоо барих утас:	1.	2.			
2 Боловсрол						
2.1	Төгссөн сургуулийн нэр	Хаана	Элссэн Он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил	Диплом, Гэрчилгээний дугаар
2.2	Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ эрхийн үнэмлэх		Дугаар:	Авсан огноо:	Дуусах огноо:	
Ажлын туршлага (Одоо эрхэлж буй ажлыг оролцуулан бичнэ)						
3	Хаана, ямар албан байгууллагад	Албан тушаал	Ажил дорсон огноо	Ажлаас гарсан огноо	Ажлаас гарсан шалтгаан	
4 Нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээлэл						

	Ямар хамааралт ай	Овог нэр	Иргэний бүртгэлийн дугаар	Төрсөн газар	Одоо эрхэлж буй ажил
5	Батламж				

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүнээр элсэхээр өргөдөл гаргагч “.....” компанийн (албан тушаал, хөрөнгө оруулагч) овогтой нь “Монголын хөрөнгийн бирж” ХК-д ирүүлсэн материалын үнэн зөвийг хариуцах бөгөөд хуурамч, худал мэдээлэл ирүүлсэн нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ. Цаашид Монгол Улсын хууль тогтоомж, уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлд мөрдөгдөж буй санхүүгийн зохицуулах Хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн холбогдох журам, заавар, гэрээтэй бүрэн танилцсан бөгөөд цаашид хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллахыг БАТАЛЖ байна.

Батламжилсан:

/Гарын үсэг/

БҮРТГЭЛИЙГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

/Гарын үсэг/

БҮРТГЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

/Компанийн захирал/

20 ... оны сарын өдөр

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

д/д	Үйлчилгээний хөлсний төрөл.	Үнийн дүн	Төлбөрийн нөхцөл	Төлөх хугацаа
1	<i>Гишүүнээр элсэх өргөдөл гаргахад төлөх үйлчилгээний хөлс</i>			
1.1.	Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокер гишүүнээр элсэх өргөдлийг хянан шийдвэрлэх үйлчилгээний хөлс	500,000 төгрөг	Буцаан олгогдохгүй	Өргөдөл гаргах үед
1.2.	Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн элсэлтийн хөлс	15,000,000 төгрөг	Нэг удаа төлнө	Шийдвэр гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор
2	<i>Гишүүнээр элссэний дараа тогтмол төлөх үйлчилгээний хөлс</i>			
2.1.	Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн хөлс	375,000 төгрөг	Улирал бүрийн хөлс	Улирал бүрийн 10-ны өдрийн дотор
2.2.	Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны терминал ашигласны эрх тус бүрийн хөлс	195,000 төгрөг	Улирал бүрийн хөлс	Улирал бүрийн 10-ны өдрийн дотор